

## **ХДХВ БОЛОН ДОХ-ЫН АСУУДЛААРХ 200 ДУГААР ЗӨВЛӨМЖ, 2010**

Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын Ерөнхий Бага Хурал нь,

Олон Улсын Хөдөлмөрийн товчооны Захиргааны зөвлөлөөс 2010 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Женев хотноо зарлан хуралдуулсан 99 дүгээр чуулганаараа

ХДХВ болон ДОХ нь нийгэм, эдийн засаг, албан ба албан бус хэвшил дэх хөдөлмөрийн харилцаанд, ажилчдад болон тэдний гэр бүл, асрамжид байдаг хүмүүст, ажил олгогчдын болон ажилчдын байгууллагуудад, төрийн болон хувийн аж ахуйн нэгжүүдэд ноцтой нөлөөлж, зохистой хөдөлмөр болон тогтвортой хөгжлийн хүрээнд олсон амжилтыг ухрааж байгааг тэмдэглэж,

Хөдөлмөрийн хүрээнд ХДХВ болон ДОХ-ын асуудлыг шийдвэрлэхэд Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гүйцэтгэх үүргийн чухлыг болон тус байгууллага нийгмийн шударга ёсыг хангах, ХДХВ болон ДОХ-ын улмаас ялгаварлан гадуурхах, гутаан доромжлох явдалтай тэмцэх чиглэлд өөрийн бүх үйл ажиллагаа, эрхийн хүрээнд гаргаж буй хүчин чармайлтаа нэмэгдүүлэх шаардлагатай байгааг дахин нотолж,

Хөдөлмөрийн хүрээнд ХДХВ болон ДОХ-ын эсрэг илүү үр дүнтэй тэмцэх зорилгоор зохистой хөдөлмөр болон тогтвортой хөгжлийг хангах замаар албан бус эдийн засгийг хумихын чухлыг санаж,

Эдийн засаг, нийгмийн тэгш бус байдал их, ойлголт мэдээлэл, итгэл үнэмшил дутмаг, эмчилгээнд хамрагдах боломж хангалтгүй, түүнчлэн ХДХВ тархах эрсдэл, нас баралтын түвшин, эцэг, эхийнхээ аль нэгийг нь юмуу хоёуланг нь алдсан хүүхдийн тоо, албан бус ажил эрхэлж байгаа ажилчдын тоо нэмэгдэж байгааг анхааралдаа авч,

Ядуурал, нийгэм, эдийн засгийн тэгш бус байдал болон ажилгүйдэл нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эмчилгээ, тусламж үйлчилгээ, дэмжлэгт хамрагдаж чадахгүй байх эрсдэлийг нэмэгдүүлж байгаагаараа тархах эрсдэлийг нэмэгдүүлж байгаа гэж үзэж,

ХДХВ болон ДОХ-той хүмүүсийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах, ажлаа алдах аюул зэрэг нь хүмүүсийн ХДХВ-тэй эсэхийг мэдэхэд саад учруулж, улмаар ажилчдын ХДХВ-т өртөх эрсдэлийг нэмэгдүүлж, нийгмийн тусламж, тэтгэмж авах эрхийг нь үгүйсгэж байгааг тэмдэглэж,

ХДХВ болон ДОХ нь эмзэг болон эрсдэл бүхий бүлгүүдийн хувьд илүү ноцтой нөлөөлдгийг анхааралдаа авч,

Эмэгтэйчүүд, охид ХДХВ-ийн халдварт илүүтэй өртөмтгий, өртөх эрсдэл өндөр бөгөөд жендэрийн тэгш бус байдлын улмаас эрэгтэйчүүдтэй харьцуулахад ХДХВ-ийн тархалт эмэгтэйчүүдийн дунд илүү байгаа боловч ХДХВ нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль алинд нь тусдаг гэдгийг, түүнчлэн дэлхийн нийтээр ХДХВ болон ДОХ-той тэмцэхэд эмэгтэйчүүдийг чадавхжуулах нь чухал хүчин зүйл болохыг тэмдэглэж,

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн цогц хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар ажилчдыг хамгаалахын чухлыг санаж, түүнчлэн ОУХБ-ын хөдөлмөрийн хүрээнд ХДХВ/ДОХ-ын асуудлаарх 2001 оны удирдамжийн ач холбогдлыг болон түүний хэрэгжилт хязгаарлагдмал, дутмаг байгаагаас үр нөлөөг нь дээшлүүлэх шаардлага байгааг сануулж,

Хөдөлмөрийн хүрээнд ХДХВ ба ДОХ-той хамааралтай олон улсын хөдөлмөрийн Конвенц, зөвлөмжүүд болон бусад олон улсын гэрээнүүд, түүний дотор эрүүл мэндийн хүрч болох дээд стандартыг хангах, амьжиргааны хүрэлцэхүйц түвшинд амьдрах эрхийг хүлээн зөвшөөрсөн гэрээ, хэлэлцээрүүдийг сурталчлах, хэрэгжүүлэх шаардлагатай байгааг тэмдэглэж,

Хөдөлмөрийн хүрээнд ХДХВ болон ДОХ-той тэмцэхэд үндэсний болон олон улсын түвшний хүчин чармайлтыг дэмжиж дэлгэрүүлэхэд ажил олгогчдын болон ажилчдын байгууллага тодорхой үүрэгтэйг сануулж,

Үндэсний хэмжээнд ХДХВ болон ДОХ-той тэмцэхэд урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эмчилгээ, тусламж үйлчилгээ, дэмжлэгийн талаар мэдээлэл хүргэх болон тэдгээрт хамрагдахад ажлын байр чухал үүрэгтэйг тэмдэглэж,

Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хүчин чармайлтыг дэмжих зорилгоор олон улсын хамтын ажиллагаа, ялангуяа ХДХВ/ДОХ-ын талаарх НҮБ-ын хамтарсан хөтөлбөрийн хүрээнд хамтын ажиллагааг үргэжлүүлэн өргөжүүлэх шаардлага байгааг нотолж, түүнчлэн үндэсний, бүсийн болон олон улсын түвшинд ХДХВ болон ДОХ-ын асуудал эрхэлсэн байгууллагуудтай, түүний дотор эрүүл мэндийн салбар, холбогдох байгууллагууд, ялангуяа ХДХВ-тэй хүмүүсийг төлөөлдөг байгууллагуудтай хамтран ажиллахын чухлыг сануулж,

Засгийн газар, ажил олгогчдын болон ажилчдын байгууллагуудыг бүх түвшинд гүйцэтгэх үүрэг, хариуцлагаа тодорхойлоход нь чиглүүлж өгөхийн тулд олон улсын стандарт тогтоох шаардлагатай байгааг нотолж,

Хөдөлмөрийн хүрээнд ХДХВ болон ДОХ-ын талаарх тодорхой саналуудыг батлахаар шийдвэрлэж,

Эдгээр саналуудыг Зөвлөмжийн хэлбэрээр гаргахаар шийдвэрлэж;

Хоёр мянга арван оны зургадугаар сарын арван долооны энэхүү өдөр дараах зөвлөмжийг ХДХВ болон ДОХ-ын тухай 2010 оны зөвлөмж гэж нэрлэхээр тогтож батлав.

## I. Тодорхойлолт

### 1. Энэхүү зөвлөмжийн зорилгод:

(a) **ХДХВ** гэж хүний дархлалын тогтолцоог гэмтээдэг хүний дархлал хомсдолын вирусийг хэлнэ. Зохих арга хэмжээ авах замаар халдвараас сэргийлж болно;

(b) **ДОХ** гэж ХДХВ-ийн халдвар гүнзгийрсэн шатанд үүсдэг дархлалын олдмол хомсдолыг хэлнэ. Энэ нь оппортунист халдвар юмуу ХДХВ хамааралт хавдар, эсвэл аль алиных нь шинж тэмдгээр тодорхойлогддог;

(c) **ХДХВ-тэй хүн** гэж ХДХВ-ийн халдвар авсан хүнийг хэлнэ;

(d) **гутаан доромжлол** гэж ХДХВ-ийн халдвар авсан буюу түүнд өртсөн хүн ихэвчлэн гадуурхахдад хүргэдэг буюу нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцоход нь саад учруулдаг нийгмийн хандлагыг хэлнэ;

(e) **ялгаварлан гадуурхалт** гэж (Хөдөлмөр эрхлэлт болон ажил мэргэжилд) ялгаварлан гадуурхахгүй байх тухай 1958 оны конвенц, мөн оны зөвлөмжид тусгагдсаны дагуу хөдөлмөр эрхлэлт буюу ажил мэргэжилд адил тэгш боломж олгох буюу адил тэгш хандахыг үгүйсгэх буюу түүнд саад учруулах аливаа ялгавар, гадуурхалт буюу давуу байдал тогтоохыг хэлнэ;

(f) **өртсөн хүмүүс** гэж ХДХВ буюу ДОХ-ын тархалтын өргөн хүрээтэй нөлөөлийн улмаас амьдрал нь өөрчлөгдсөн хүмүүсийг хэлнэ;

(g) **боломжит зохицуулалт** гэж ХДХВ буюу ДОХ-той хүн хөдөлмөр эрхлэх, эсвэл ажил хөдөлмөрт оролцох буюу ахиж дэвших боломж олгох зорилгоор ажил буюу ажлын байранд оруулж буй хэрэгжиж болохуйц аливаа өөрчлөлт буюу зохицуулалтыг хэлнэ;

(h) **эмзэг байдал** гэж хүн ХДХВ-ийн халдвар авч, ДОХ тусах эрсдэлийг өндөрсгөж буй нийгэм, эдийн засаг, соёл, улс төрийн болон эдийн засгийн хүчин зүйлүүдээс үүдсэн тэгш бус боломж, нийгмийн гадуурхал, ажилгүйдэл болон баталгаагүй ажил;

(i) **ажлын байр** гэж ажилчид ажил үүргээ гүйцэтгэдэг газрыг хэлнэ;

(j) **ажилчин** гэж ямар ч хэлбэрээр буюу ямар ч гэрээгээр ажил гүйцэтгэж буй хүмүүсийг хэлнэ.

## II. Хамрах хүрээ

### 2. Энэхүү зөвлөмжид:

(a) бүх төрлийн гэрээгээр буюу хэлбэрээр, бүх төрлийн ажлын байранд ажиллаж буй ажилчид, түүний дотор:

(i) ажил эрхэлж буй хүн;

(ii) сургалтад хамрагдаж буй хүмүүс, түүнчлэн мэргэжил дээшлүүлэгчид болон дагалдан суралцагчид;

(iii) сайн дурын ажилтнууд;

(iv) ажил хайгчид болон ажилд орохоор өргөдөл гаргагчид;

(v) ажлаасаа халагдсан болон ажлаас түр чөлөөлөгдсөн ажилчид;

(b) эдийн засгийн үйл ажиллагааны бүх салбар, түүний дотор хувийн болон улсын сектор, албан ба албан бус эдийн засаг;

(c) зэвсэгт хүчний болон дүрэмт хувцаст албан хаагчид.

### III. Ерөнхий зарчмууд

3. Хөдөлмөрийн хүрээнд ХДХВ болон ДОХ-той тэмцэх үндэсний арга хэмжээний бүх үйл ажиллагаанд дараах ерөнхий зарчмуудыг баримталбал зохино. Үүнд:

(a) ХДХВ болон ДОХ-ын эсрэг авах арга хэмжээ нь хүн бүрт, түүний дотор ажилчид болон тэдний гэр бүлийнхэн, асрамжид нь байдаг хүмүүст хүний эрх, үндсэн эрх чөлөө болон жендерийн тэгш эрхийг эдлүүлэхэд хувь нэмэр оруулдаг гэдгийг хүлээн зөвшөөрвөл зохино;

(b) ХДХВ болон ДОХ-ыг цартахлын эсрэг үндэсний, бүсийн болон олон улсын түвшинд ажил олгогчдын болон ажилчдын байгууллагуудын бүрэн оролцоотойгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээний бүрэлдэхүүнд зайлшгүй байх элементүүдийн тоонд оруулбал зохих ажлын байрны асуудал гэж хүлээн зөвшөөрч авч үзвэл зохино;

(c) ажилчдыг, ялангуяа ажил хайгчдыг болон ажилд орохоор өргөдөл гаргагчдыг ХДХВ–тэй буюу эсвэл халдвартай байж болзошгүй гэж үзсэний улмаас, эсвэл тэднийг дэлхий дээр ХДХВ-ийн халдвар тусах эрсдэл өндөртэй буюу халдварт илүү өртемхий гэж үздэг газар нутаг буюу хүн амын бүлгээс гаралтай гэдгээр нь ялгаварлан гадуурхах буюу гутаан доромжлохгүй байвал зохино;

(d) ХДХВ-ийн халдвар тархалтаас бүх аргаар урьдчилан сэргийлэх нь нэн тэргүүний зорилт байвал зохино;

(e) ажилчид болон тэдний гэр бүл, асрамжид нь байдаг хүмүүс ХДХВ болон ДОХ-оос урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эмчилгээ, тусламж үйлчилгээ болон дэмжлэгт хамрагдаж, үр дүнг нь хүртэх боломжтой байвал зохино. Түүнчлэн эдгээр үйлчилгээнд хамрагдахад нь дэмжлэг үзүүлэхэд ажлын байр үүрэг гүйцэтгэх ёстой;

(f) үндэсний болон ажлын байрны хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд оролцох ажилчдын оролцоог хүлээн зөвшөөрч бататгавал зохино;

(g) ажилчид ажил мэргэжлийн улмаас ХДХВ-ийн болон сүрьеэ зэрэг бусад халдварт өвчин тусах тодорхой эрсдэлүүдээс сэргийлэх хөтөлбөрүүдэд хамрагдвал зохино;

(h) ажилчид, тэдний гэр бүлийнхэн болон асрамжид байдаг хүмүүс нь хувийн нууц, түүний дотор ХДХВ болон ДОХ-той холбоотой нууцлал, ялангуяа өөрсдийнх нь ХДХВ-тэй эсэх талаарх мэдээллийн нууцаа хамгаалуулах ёстой;

(i) ажилчдаас ХДХВ-ийн шинжилгээ хийлгэх буюу ХДХВ-тэй эсэхээ мэдэгдэхийг шаардах ёсгүй;

(j) хөдөлмөрийн хүрээнд ХДХВ болон ДОХ-той тэмцэх арга хэмжээ нь үндэсний хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд, түүний дотор хөдөлмөр, боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн бодлого, хөтөлбөрүүдийн нэг хэсэг нь байвал зохино;

(k) ХДХВ-ийн халдвар дамжих эрсдэл бүхий ажил мэргэжилд ажилладаг ажилчдыг хамгаалах.

#### IV. Үндэсний бодлого, хөтөлбөрүүд

##### 4. Гишүүд нь:

(a) хөдөлмөрийн хүрээн дэх ХДХВ болон ДОХ, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх үндэсний бодлого, хөтөлбөрүүд байхгүй нөхцөлд тэдгээрийг батлан гаргана;

(b) хөдөлмөрийн хүрээн дэх ХДХВ болон ДОХ-ын талаарх бодлого, хөтөлбөрүүдийг боломжоороо хөгжлийн төлөвлөгөө, ядуурлыг бууруулах стратеги, түүний дотор зохистой хөдөлмөр, тогтвортой аж ахуй, орлого бий болгох стратегиудад суулгаж өгнө.

5. Эрх бүхий байгууллагууд үндэсний бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулахдаа ОУХБ-ын ХДХВ/ДОХ-ын талаар баримтлах 2001 оны удирдамж, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүд, ОУХБ-ын бусад холбогдох хэм хэмжээ, энэ ауудлаар гарсан олон улсын бусад удирдамжуудыг харгалзан үзвэл зохино.

6. Эрх бүхий байгууллагаас үндэсний бодлого, хөтөлбөрүүдийг ажил олгогчдын болон ажилчдын хамгийн өргөн төлөөлөл бүхий байгууллагууд, түүнчлэн ХДХВ-тэй хүмүүсийн төлөөллийн байгууллагуудтай зөвлөлдөн холбогдох салбарууд ялангуяа эрүүл мэндийн салбарын санал бодлыг харгалзан боловсруулбал зохино.

7. Эрх бүхий байгууллагууд үндэсний бодлого, хөтөлбөрүүдийг боловсруулахдаа орон нутгийн ард иргэдтэй хамтран урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эмчилгээ, тусламж үйлчилгээ, дэмжлэг, түүний дотор сайн дурын зөвлөгөө, шинжилгээг дэмжихэд ажлын байрны гүйцэтгэх үүргийг харгалзан үзвэл зохино.

8. Гишүүд хөдөлмөрийн хүрээний ХДХВ болон ДОХ-ын талаарх бодлого, хөтөлбөрүүдийнхээ тухай мэдээллийг ажил олгогчид болон ажилчдын байгууллагууд,

ХДХВ болон ДОХ-ын асуудлаар ажилладаг бусад холобгдох байгууллагууд, олон нийтийн мэдээллийн сувгуудаар дамжуулан түгээх бүхи йл боломжийг ашиглавал зохино.

Ялгаварлан гадуурхалт ба тэгш боломж олгож, адил тэгш хандах

9. Засгийн газрууд ажил олгогчдын болон ажилчдын хамгийн өргөн төлөөлөл бүхий байгууллагуудтай зөвлөлдөн ХДХВ-тэй буюу эсвэл халдвартай байж болзошгүй гэж үзсэний улмаас ялгаварлан гадуурхахаас сэргийлэхийн тулд (Хөдөлмөр эрхлэлт болон ажил мэргэжилд) ялгаварлан гадуурхахгүй байх тухай 1958 оны конвенцид тусгагдсан стандарттай дүйцэхүйц хамгаалалтыг бий болгох асуудлыг авч үзвэл зохино.

10. ХДХВ-тэй буюу эсвэл халдвартай байж болзошгүй байдал нь ажилд авах, ажлаа үргэлжлүүлэн хийх буюу (Хөдөлмөр эрхлэлт болон ажил мэргэжилд) ялгаварлан гадуурхахгүй байх тухай 1958 оны конвенцийн заалтуудын дагуу тэгш боломж олгоход саад учруулж ялгаварлан гадуурхах үндэслэл болох ёсгүй.

11. ХДХВ-тэй буюу эсвэл халдвартай байж болзошгүй байдал нь хөдөлмөр эрхлэлтийг дуусгавар болгох шалтгаан болох ёсгүй. ХДХВ буюу ДОХ-оор өвчилсний улмаас, эсвэл тийнхүү өвчилсөн хүмүүсийг асарсны улмаас ажлаасаа түр хугацаагаар завсардахыг Хөдөлмөр эрхлэлтийг дуусгавар болгох тухай 1982 оны конвенцийг харгалзан эрүүл мэндийн бусад шалтгааны улмаас ажлаасаа завсардахтай адилтган үзвэл зохино.

12. Ажлын байранд ялгаварлан гадуурхахын эсрэг одоогийн хэрэгжүүлж буй арга хэмжээ нь ХДХВ болон ДОХ-той холбоотойгоор ялгаварлан гадуурхахаас үр дүнтэй хамгаалахад хангалтгүй байгаа үед гишүүд эдгээр арга хэмжээндээ өөрчлөлт оруулах буюу шинийг нэвтрүүлэх, тэдгээрийн үр дүнтэй, ил тод хэрэгжилтийг хангавал зохино.

13. ХДХВ-тэй холбоотойгоор өвчилсөн хүмүүсийн эрүүл мэндийн хувьд ажлаа үргэлжүүлэн хийх боломжтой байгаа нөхцөлд шаардлагатай бол боломжит зохицуулалт хийх замаар ажлаа үргэлжлүүлэх боломжийг нь үгүйсгэхгүй байвал зохино. ОУХБ-ын болон НҮБ-ын холбогдох гэрээ, хэлэлцээрүүдийг харгалзан үзэж ийм хүмүүсийг чадварт нь тохируулж боломжит зохицуулалт хийсэн ажилд шилжүүлэх, сургалтад хамрагдаж өөр ажил олох буюу эргээд ажиллахыг нь дэмжихэд чиглэсэн арга хэмжээг хөхиүлэн дэмжвэл зохино.

14. Дараах замаар ХДХВ-ийн тархалтыг бууруулах болон түүний нөлөөг арилгахад чиглэсэн арга хэмжээг ажлын байранд буюу түүгээр дамжуулан авч хэрэгжүүлбэл зохино:

(a) хүний эрх, үндсэн эрх чөлөөний хэрэгжилтийг хангах;

(b) жендерийн тэгш байдлыг хангах болон эмэгтэйчүүдийг чадавхжуулах;

(с) ажлын байранд хүчирхийлэл, дарамтаас сэргийлэх, тэдгээрийг хориглох арга хэмжээг авах;

(d) ХДХВ болон ДОХ-ын эсрэг арга хэмжээнд эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн алиных нь идэвхтэй оролцоог дэмжих;

(e) бэлгийн чиг баримжаа болон эмзэг бүлэгт хамрагдаж буй эсэхийг нь үл харгалзан бүх ажилчдыг оролцуулах, чадавхжуулахыг дэмжих;

(f) бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүдийн бэлгийн болон нөхөн үржихүйн эрхийг хамгаалахыг дэмжих;

(g) хувийн мэдээлэл, түүний дотор эрүүл мэндийн мэдээллийн нууцыг үр дүнтэй хангах.

#### Урьдчилан сэргийлэлт

15. Урьдчилан сэргийлэх стратегийг үндэсний нөхцөл байдал болон ажлын байрны төрөлд тохируулан өөрчлөх, түүнчлэн жендэрийн, соёлын, эдийн засаг, нийгмийн асуудлуудыг нь анхааран авч үзвэл зохино.

16. Урьдчилан сэргийлэх хөтөлбөрүүд нь:

(a) үнэн зөв, шинэчилсэн, хамааралтай бөгөөд цаг үеийн мэдээллийг соёлын мэдрэмжтэй хэлбэрээр болон хэлээр бэлтгэж, харилцааны боломжит сувгуудаар бүх нийтэд хүртээмжтэй хүргэх

(b) эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийг ХДХВ тархах бүх хэлбэрүүд, түүний дотор эхээс хүүхдэд дамжих хэлбэрийн эрсдэлийг ойлгож бууруулах, мөн халдвартай холбоотой эрсдэлт зан үйлийг өөрчлөхийн ач холбогдлыг ойлгоход нь туслах;

(c) хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн үр дүнтэй арга хэмжээ авах;

(d) ажилчид сайн дурын шинжилгээ, зөвлөгөөнд хамрагдах замаар ХДХВ-тэй эсэхээ мэдэхийг нь дэмжих арга хэмжээ авах;

(e) урьдчилан сэргийлэх бүх арга хэрэгслийг, ялангуяа эрэгтэй, эмэгтэй бэлгэвчийг хүртээмжтэй байлгах, шаардлагатай хэрэгслийн хангамжийг баталгаажуулаад зогсохгүй зохистой нөхцөлд тэдгээрийн зөв хэрэглээний талаарх мэдээлэл болон эрсдэлд өртсөний дараа сэргийлэх боломжийг бүрдүүлэх;

(f) ХДХВ-ийн тохиолдлыг бууруулах зорилгоор өндөр эрсдэлт зан үйлийг, түүний дотор эрсдэлд хамгийн ойр байгаа бүлгүүдийн эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авах;

(г) Дэлхийн эрүүл мэндийн байгууллага(ДЭМБ), НҮБ-ын ХДХВ/ДОХ-ын хамтарсан хөтөлбөр, НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх албанаас гаргасан удирдамжид үндэслэсэн хохирлыг бууруулах стратеги болон бусад холбогдох удирдамжууд.

Эмчилгээ ба тусламж үйлчилгээ

17. Гишүүн орнууд ажлын байран дахь эрүүл мэндийн талаарх үндэсний бодлого, хөтөлбөрүүд нь ажил олгогчид болон ажилчид, тэдгээрийн төлөөлөгчидтэй зөвлөлдөн тодорхойлж, тэдгээрийг нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээтэй холбож өгвөл зохино. Тэд ХДХВ болон ДОХ-оос сэргийлэх, тэдний нөлөөг зохицуулахын тулд хамгийн өргөн сонголт бүхий тохиромжтой бөгөөд үр дүнтэй арга хэмжээнүүдийг санал болгох нь зүйтэй.

18. Гишүүн орнууд ХДХВ-тэй ажилчид болон тэдний асрамжид байдаг хүмүүс төрийн эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн даатгалын систем, хувийн даатгал буюу бусад тогтолцоогоор үзүүлж буй эсэхээс үл хамааран эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд бүрэн хамрагдах боломжийг хангана. Мөн гишүүн орнууд ажилчдыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдахад нь тус дөхөм болох зорилгоор тэдний боловсрол, ойлголтыг дээшлүүлэх арга хэмжээ авбал зохино.

19. Энэхүү зөвлөмжид хамрагдаж буй бүх хүмүүс, түүний дотор ХДХВ-тэй ажилчид, тэдний гэр бүлийнхэн болон асрамжинд нь байдаг хүмүүс эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхтэй байвал зохино.

Эдгээр үйлчилгээнд үнэгүй буюу боломжийн үнээр хамрагдаж болох дараах үйлчилгээ багтвал зохино:

(a) сайн дурын зөвлөгөө болон шинжилгээ;

(b) ретровирусийн эсрэг эмчилгээ, баримтлах дэглэмийн талаарх сургалт, мэдээлэл, дэмжлэг;

(c) эмчилгээтэйгээ уялдсан зохистой хоол тэжээл;

(d) оппортунист халдвар болон бэлгийн замаар дамждаг халдвар, ХДХВ-ийн хамааралтай бусад өвчлөл, тухайлбал, сүрьеэгийн эмчилгээ;

(e) ХДХВ-тэй хүмүүст дэмжлэг үзүүлэх болон урьдчилан сэргийлэх хөтөлбөр, түүний дотор нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг.

20. Ажилчдыг буюу тэдний асрамжид байдаг хүмүүсийг нийгмийн даатгалын системд болон мэргэжлийн даатгалын тогтолцоонд хамруулахад, эсвэл тэдгээр тогтолцооноос, түүний дотор эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөдөлмөрийн чадвараа алдсаны, нас барсны болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр, тэтгэмж авахад нь ХДХВ-тэй буюу халдвартай байж болзошгүй гэсэн үндэслэлээр ялгаварлан гадуурхаж болохгүй.



## Дэмжлэг

21. Тусламж үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх хөтөлбөрүүдэд үндэсний нөхцөл байдлыг зохих ёсоор харгалзан ХДХВ-тэй буюу ХДХВ-ийн хамааралтай өвчин туссан хүмүүст зориулан ажлын байранд боломжит зохицуулалт хийх арга хэмжээг багтаавал зохино. ХДХВ болон ДОХ-ын тухайн тохиолдлын шинж чанарт, түүнчлэн эмчилгээний болзошгүй сөрөг нөлөөлөлд тохируулах байдлаар ажлыг зохион байгуулбал зохино.

22. Гишүүн орнууд ХДХВ-тэй хүмүүсийг ажилд нь үргэлжлүүлэн ажиллуулах болон ажилд авах явдлыг дэмжвэл зохино. Гишүүн орнууд ХДХВ-тэй хүмүүс болон ХДХВ буюу ДОХ-д өртсөн хүмүүст ажилтай болон ажилгүй байх хугацаанд нь дэмжлэг үзүүлэх, түүний дотор шаардлагатай нөхцөлд орлого бий болгох боломжоор хангах асуудлыг авч үзвэл зохино.

23. Ажил мэргэжил халдвар авах эрсдэлтэй шууд холбоотой нь тогтоогдвол ДОХ болон ХДХВ-ийн халдварыг үндэсний журам болон тодорхойлолтын дагуу 2002 оны Мэргэжлээс шалтгаалсан өвчний жагсаалт болон Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын бусад холбогдох хэм хэмжээг харгалзан мэргэжлээс шалтгаалсан өвчин буюу үйлдвэрлэлийн осол гэж хүлээн зөвшөөрөх нь зүйтэй.

## Шинжилгээ, хувийн нууц болон нууцлал

24. Шинжилгээнд зөвхөн сайн дурын үндсэн дээр ямар нэгэн албадлагагүйгээр хамруулах ёстой. Шинжилгээнд хамруулах хөтөлбөрүүд нь нууцлалыг хадгалах, зөвлөгөө өгөх, зөвшөөрөл авах зэрэг асуудлаарх олон улсын удирдамжуудыг баримтлах ёстой.

25. ХДХВ-ийн шинжилгээ буюу ХДХВ-ийн бусад хэлбэрийн сорил хийлгэхийг ажилчид, түүний дотор цагаач ажилчид, ажил хайгчид болон ажилд орохоор өргөдөл гаргагчдаас шаардаж болохгүй.

26. ХДХВ-ийн шинжилгээний хариуны нууцлалыг хадгалж, ажилд орох, албан тушаалдаа үлдэх, ажлын байрны баталгаа болон ахиж дэвших боломжид нь аюул учруулахгүй байвал зохино.

27. Илгээж буй, дамжиж буй болон хүлээн авч буй орнууд нь ажилчид, түүний дотор цагаач ажилчид, ажил хайгчид болон ажилд орохоор өргөдөл гаргагчдаас өөрсдийнхөө болон бусдын ХДХВ-тэй холбоотой мэдээллийг задруулахыг шаардаж болохгүй. Ийм мэдээллийг Ажилчдын хувийн мэдээллийг хамгаалах тухай ОУХБ-ын 1997 оны удирдамж болон мэдээлэл хамгаалалтын холбогдох олон улсын стандартын дагуу нууцлалыг хадгалах журмаар зохицуулбал зохино.

28. Цагаач ажилчид буюу ажил хайж шилжин суурьшихыг завдагсдыг тэднийг илгээгч, дамжин өнгөрүүлэгч буюу хүлээн авагч орнууд ХДХВ-тэй буюу халдвартай байж болзошгүй гэсэн үндэслэлээр шилжилт хөдөлгөөнөөс хасч болохгүй.

29. Гишүүн орнууд ажилчдын дээр дурьдсан эрх зөрчигдвөл эрхийг нь сэргээх маргаан шийдвэрлэх хялбар дөхөм журмыг нэвтрүүлбэл зохино.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй

30. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн тухай 1981 оны конвенц, 1981 оны зөвлөмж, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйг дэмжих суурь тогтолцооны тухай 2006 оны конвенц, 2006 оны зөвлөмж болон ОУХТ, ДЭМБ-ын хамтарсан баримт бичгүүд зэрэг холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийг харгалзан ажлын байранд ХДХВ-ийн халдвар тархахаас сэргийлэхийн тулд ажиллах орчин нь аюулгүй, эрүүл байх ёстой.

31. Ажилчдыг ажил дээрээ ХДХВ-ийн халдварт өртөхөөс сэргийлэх аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээнд зохион байгуулалтын арга хэмжээ, инженерингийн болон ажлын хяналт, хувийн хамгаалах хэрэгсэл, боломжтой бол орчны хяналтын арга хэмжээ, эрсдэлд өртсөний дараа сэргийлэх, түүнчлэн ХДХВ болон сүрьеэгийн халдварыг ялангуяа эрсдэл хамгийн өндөртэй ажил мэргэжилд, түүний дотор эрүүл мэндийн салбарт авах эрсдэлийг багасгах аюулгүйн бусад арга хэмжээг багтаавал зохино.

32. Ажил дээрээ ХДХВ-т өртөх боломжтой бол ажилчид халдвар дамжих арга зам болон халдварт өртөх, авах арга хэмжээний талаарх сургалтад хамрагдах ёстой. Гишүүн орнууд урьдчилан сэргийлэх болон аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг холбогдох стандартын дагуу авч хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг авбал зохино.

33. Ойлголт бий болгох арга хэмжээнд ХДХВ нь ахуйн хавьтлын замаар халддаггүй болхыг онцлох нь зүйтэй бөгөөд ХДХВ-тэй хүн байхыг ажлын байрны аюул эрсдэл гэж үзэхгүй байвал зохино.

34. Хөдөлмөрийн эрүүл ахуйн үйлчилгээ болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйтай холбоотой ажлын байрны механизм нь ХДХВ болон ДОХ-ыг Хөдөлмөрийн эрүүл ахуйн албаны тухай 1985 оны конвенц, 1985 оны зөвлөмж, эрүүл мэндийн үйлчилгээ болон ХДХВ/ДОХ-ын талаарх ОУХБ/ДЭМБ-ын хамтарсан 2005 оны удирдамж, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон олон улсын бусад холбогдох баримт бичгүүдийг харгалзан авч үзвэл зохино.

Хүүхдүүд ба залуучууд

35. Гишүүн орнууд ОУХБ-ын хөдөлмөрийн хүрээний үндсэн эрх, суурь зарчмуудын тухай 1998 оны тунхаглал, Ажилд авах насны доод хязгаарын тухай 1973 оны конвенц, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 1999 оны конвенцийг харгалзан ДОХ-ын улмаас гэр бүлийн гишүүдээ алдсан, гэр бүлийн гишүүд нь өвчилсөн буюу өвчтөн асрамжилж байгаагаас үүсч болох хүүхдийн хөдөлмөр болон хүүхдийг дамжуулан худалдах явдалтай тэмцэх, түүнчлэн хүүхдүүдийн ХДХВ-т өртөх эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг авбал зохино. Эдгээр хүүхдийг бэлгийн хүчирхийлэл болон бэлгийн мөлжлөгөөс хамгаалах тусгай арга хэмжээг авбал зохино.

36. Гишүүн орнууд залуучуудыг ХДХВ-ийн халдвараас хамгаалах, үндэсний бодлого, хөтөлбөрүүдийн ХДХВ болон ДОХ-той тэмцэх хэсэгт хүүхэд, залуусын онцлог хэрэгцээг тусгах арга хэмжээг авбал зохино. Үүнд бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол, тухайлбал мэргэжлийн сургалт, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөр болон үйлчилгээгээр дамжуулан ХДХВ болон ДОХ-ын тухай мэдээлэл түгээх зэргийг багтаавал зохино.

#### V. Хэрэгжилт

37. Хөдөлмөрийн хүрээний ХДХВ болон ДОХ-ын бодлого, хөтөлбөрүүд нь:

(a) ажил олгогчид болон ажилчдын хамгийн өргөн төлөөлөлтэй байгууллагууд болон бусад холбогдох талууд, түүний дотор холбогдох төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудтай зөвлөлдөн дараах аргуудын аль нэгээр буюу тэдгээрийг хослуулах байдлаар хэрэгжвэл зохино:

(i) үндэсний хууль тогтоомж;

(ii) хамтын гэрээ;

(iii) үндэсний болон ажлын байрны бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр;

(iv) салбарын стратеги, ингэхдээ энэхүү зөвлөмжид хамрагдаж буй хүмүүс хамгийн эрсдэл өндөртэй байгаа салбаруудыг онцгойлон анхаарах;

(b) хөдөлмөрийн асуудлаар мэргэшсэн шүүхийн болон хөдөлмөрийн удирдлагын эрх мэдэлтнүүдийг бодлого, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцуулах, энэ асуудлаар тэдэнд сургалт явуулбал зохино;

(c) хувийн нууц, нууцлал, түүнчлэн энэ конвенцид заасан бусад хамгаалалтыг зөрчсөн тохиолдолд шийдвэрлэх арга хэмжээг үндэсний хууль болон журамд тусгах;

(d) төрийн байгууллагууд, төрийн болон хувийн хэвшлийн холбогдох албад, түүний дотор даатгалын болон тэтгэмж тусламж олгодог хөтөлбөрүүд буюу бусад хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа, хамтын ажиллагааг хангах;

(e) бүх аж ахуйн нэгжүүд өөрсдийн ханган нийлүүлэлтийн болон түгээлтийн сүлжээг хамруулан ажил олгогчид болон ажилчдын байгууллагуудын оролцоотойгоор үндэсний бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийг дэмжин туслах, экспортын үйлдвэрлэлийн бүсэд ажиллаж буй аж ахуйн нэгжүүдэд эдгээрийг дагаж мөрдүүлэх;

(f) (Олон Улсын Хөдөлмөрийн хэм хэмжээ)-ний талаарх гурван талт зөвлөлдөөний тухай 1976 оны конвенцид нийцүүлэн Засгийн газрын байгууллагууд, төрийн болно хувийн хэвшлийн ажил олгогчид, ажилчид, тэдгээрийн төлөөлөгчдийн дунд нийгмийн түншлэл, түүний дотор зөвлөлдөөн, хэлэлцээг дэмжих, ингэхдээ хөдөлмөрийн эрүүл ахуйн мэргэжилтнүүд, ХДХВ болон ДОХ-ын мэргэжилтнүүд, бусад талууд, түүний

дотор ХДХВ-тэй хүмүүсийг төлөөлдөг байгууллагууд, олон улсын байгууллагууд, холбогдох иргэний нийгмийн байгууллагууд, зохицуулах механизмуудын санаа бодлыг харгалзан үзэх;

(g) үндэсний бодлого, хөтөлбөрүүдийг хамгийн сүүлийн үеийн шинжлэх ухааны болон нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүд, түүнчлэн жендерийн болон соёлын асуудлуудыг тусгах шаардлагыг харгалзан боловсруулах, хэрэгжүүлэх, тогтмол хянан шинэчилж байх;

(h) хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн болон бусад бодлого, хөтөлбөрүүдийн хоорондын уялдаа зохицуулалтыг хангах;

(i) Гишүүн орнууд үндэсний нөхцөл байдал болон ажил олгогчдын болон ажилчдын чадавхийн байдлыг зохих ёсоор харгалзан тэдгээрийг хэрэгжүүлэх боломжит арга хэрэгслээр хангах.

#### Нийгмийн зөвшил

38. ХДХВ болон ДОХ-ын талаарх бодлого, хөтөлбөрүүдийн хэрэгжилт нь ХДХВ-тэй хүмүүсийн идэвхтэй оролцоотойгоох ажлын байранд ажил олгогчид болон ажилчид, тэдгээрийн төлөөлөгчид, засгийн газруудын хоорондын хамтын ажиллагаа, итгэлцэл дээр тулгуурлавал зохино.

39. Ажил олгогчдын болон ажилчдын байгууллагууд нь гишүүдээ сургах, мэдээлэл хүргэх замаар ХДХВ болон ДОХ, түүний дотор урьдчилан сэргийлэх, үл ялгаварлах талаарх ойлголтыг дэлгэрүүлбэл зохино. Эдгээр нь жендерийн болон соёлын мэдрэмжтэй байвал зохино.

#### Боловсрол, сургалт, мэдээлэл, зөвлөгөө

40. ХДХВ болон ДОХ-той холбоотой сургалт, аюулгүйн зааварчилгаа, ажлын байранд шаардлагатай заавар, чиглэлүүдийг ойлгомжтой, нийт ажилчдад, ялангуяа цагаач ажилчид, шинээр орсон болон туршлагагүй ажилчид, залуу ажилчид, сургалтад хамрагдаж буй хүмүүс, мэргэжил дээшлүүлэгчид болон дадлагажигчдад хүртээмжтэй хүргэвэл зохино. Сургалт, зааварчилгаа болон удирдамж чиглэл нь жендерийн болон соёлын асуудлуудад мэдрэмжтэй, ажиллах хүчний онцлогт тохирсон, эрсдэлт хүчин зүйлүүдийг нь харгалзан үзсэн байвал зохино.

41. Ажил олгогчид, менежерүүд, ажилчдын төлөөлөгчдөд ажлын байранд зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд нь туслах зорилгоор ХДХВ болон ДОХ-ын талаарх шинжлэх ухааны болон нийгэм-эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн мэдээлэл авах, боломжтой бол боловсрол, сургалтад хамрагдах боломжийг бүрдүүлсэн байвал зохино.

42. Ажилчид, түүний дотор мэргэжил дээшлүүлэгчид, сургалтад хамрагдагчид, сайн дурын ажилтнууд нь ажлын байрны ослын болон анхны тусламж үзүүлэх нөхцөлд

ХДХВ-ийн халдварын тархалтад хяналт тавих журмын талаар зохих мэдээлэл авч, сургалтад хамрагдах ёстой. Хүний цус, цусан бүтээгдэхүүн болон биеийн бусад шингэнтэй харьцдаг эрсдэлтэй ажил мэргэжилд ажилладаг ажилчид нь халвдараас урьдчилан сэргийлэх, халдвар авах эрсдэлд орсон тохиолдлыг бүртгэх журам, эрсдэлд өртсөний дараа авах арга хэмжээний талаар нэмэлт сургалтад хамрагдвал зохино.

43. Ажилчид болон тэдний төлөөлөгчид нь ХДХВ болон ДОХ-той холбоотой ажлын байрны бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор авч буй арга хэмжээний талаар мэдээлэл авах, зөвлөлдөх эрхтэй байвал зохино. Ажилчид, ажил олгогчдын төлөөлөгчид үндэсний практикийн дагуу ажлын байрны үзлэг шалгалтад оролцвол зохино.

#### Төрийн үйлчилгээ

44. ХДХВ болон ДОХ-той тэмцэхэд хөдөлмөрийн удирдлагын байгууллага, түүний дотор хөдөлмөрийн хяналтын, түүнчлэн хөдөлмөрийн асуудлаар дагнасан шүүхийн байгууллагын гүйцэтгэх үүргийг хянан үзэж, шаардлагатай бол бэхжүүлэх арга хэмжээ авбал зохино.

45. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эмчилгээ, тусламж үйлчилгээ, дэмжлэгийн хүртээмжийг сайжруулах, улмаар ХДХВ болон ДОХ-ын улмаас төрийн үйлчилгээнд, ялангуяа эрүүл мэндийн ажилчдад ногдох нэмэлт ачааллыг бууруулахын тулд нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, ОУХБ/ДЭМБ-ын хамтарсан эрүүл мэндийн үйлчилгээ болон ХДХВ/ДОХ-ын асуудлаарх удирдамж, түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийг мөрдвөл зохино.

#### Олон Улсын хамтын ажиллагаа

46. Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлэхийн тулд гишүүн орнууд хоёр буюу олон талт гэрээгээр дамжуулан олон талт системд оролцох замаар буюу бусад үр дүнтэй арга хэрэгслээр хамтран ажиллах нь зүйтэй.

47. Цагаач ажилчдыг илгээгч, дамжуулан өнгөрүүлэгч, хүлээн авагч орнууд тэднийг ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, эмчилгээ, тусламж үйлчилгээ, дэмжлэгт хамруулах арга хэмжээг авбал зохино. Боломжтой нөхцөлд холбогдох орнууд хоорондоо гэрээ, хэлэлцээр байгуулах нь зүйтэй.

48. Гишүүн орнууд хоорондын болон ХДХВ ба олон ДОХ-ын асуудлаар ажилладаг үндэсний байгууллагууд, холбогдох олон улсын байгууллагуудын хооронд хамтран ажиллахыг дэмжиж, үүндээ ХДХВ-ийн цартахлын эсрэг авсан бүх арга хэмжээний талаар системтэй мэдээлэл солилцох явдлыг багтаавал зохино.

49. Бүх улс орнуудын, түүний дотор тархалт өндөртэй орнуудын хэрэгцээ шаардлагыг хангах үүднээс ХДХВ-ээс урьдчилан сэргийлэх, эмчлэх, тусламж үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх талаарх олон улсын стратеги, хөтөлбөрүүдийг боловсруулахад зохицуулалт

болон шаардлагатай нөөцийн асуудалд гишүүн орнууд болон олон талт байгууллагууд тухайлан анхаарал хандуулбал зохино.

50. Гишүүн орнууд болон олон улсын байгууллагууд нь ХДХВ-ийн халдвар, бусад оппортунист халдвар, ХДХВ-ийн хамааралтад хавдараас урьдчилан сэргийлэх, эмчлэх, тусламж үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон аливаа төрлийн хэрэгслийг ханган нийлүүлэх үнийг бууруулахыг эрмэлзвэл зохино.

#### VI. Дараачийн арга хэмжээ

51. Гишүүн орнууд хөдөлмөрийн хүрээнд ХДХВ болон ДОХ-ын асуудлаарх үндэсний бодлогодоо мониторинг хийх, түүнчлэн түүнийг баталж хэрэгжүүлэхэд чиглэсэн зөвлөмж боловсруулахад тохирох механизмыг бий болгох буюу хүчин төгөлдөр хэрэгжиж буй механизмыг ашиглавал зохино.

52. Үндэсний бодлогод мониторинг хийх механизмд ажил олгогчдын болон ажилчдын хамгийн өргөн төлөөлөл бүхий байгууллагуудыг адил тэгш оролцуулах нь зүйтэй. Түүнчлэн тухайн механизмын хүрээнд ХДХВ-тэй хүмүүсийн байгууллагуудын санаа бодол, экспертүүдийн илтгэл буюу арга зүйн судалгаануудыг харгалзан эдгээр байгууллагуудтай шаардлагатай хугацаанд зөвлөлдөж байвал зохино.

53. Гишүүн орнууд нь боломжтой хэмжээнд хөдөлмөрийн хүрээний Members ХДХВ болон ДОХ-ын асуудлаар үндэсний болон салбарын түвшинд эмэгтэй, эрэгтэйчүүдийн харьцаа, бусад холбогдох хүчин зүйлүүдийг харгалзан дэлгэрэнгүй мэдээлэл, статистик цуглуулах, судалгаа хийх арга хэмжээг авбал зохино.

54. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дүрмийн 19 дүгээр зүйлийн дагуу тайлагнахаас гадна энэхүү зөвлөмжийн үндсэн дээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тогтмол мэдээллийг НҮБ-ын ДОХ-ын асуудал эрхэлсэн хөтөлбөр болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийн талаарх үндэсний тайландаа тусгаж болох юм.

-oOo-